



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 437

Улаанбаатар хот

Хорооны 2014 оны 8 дугаар тогтоолоор
батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 8 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 3.1.10 дахь заалт:


“3.1.10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”;

2/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 11 дэх заалт:

“3.1.11. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр”.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН